СУРГАЛТЫН ТӨВИЙН БАГШ-ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НЯМДОРЖИЙН АНУЖИНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | 1. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ын ёс зүйн шалгуур хэсэгт санал хүргүүлсэн.<br>2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуультай уялдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 534 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэх төсөлтэй танилцаж, санал боловсруулан хүргүүлсэн.<br>3. "Гаалийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаа илэрхийлсэн баталгааны маягтад тус төвийн багш- гаалийн улсын байцаагч нараар гарын үсэг зуруулж ЗУГ-т хүргүүлсэн.<br>4. Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагаанд ISO 9001:2015 болон ISO 27001:2022 стандартын хэрэгжилтэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх "Ажлын даалгавар"-ын төслийн 9 дүгээр бүлэг "Гүйцэтгэлийн үнэлгээ" хэсэгт санал хүргүүлсэн.<br>5. 2025 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс боловсруулсан "Гаалийн байгууллагын сургалтын журам"-д санал хүргүүлсэн. | 01.01-06.10 | 100 |
| **Зорилт 4."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 1 | Сургалтын хэрэгцээ шаардлагыг | Хэрэгжилт, | - | Эхний хагас жилд:<br>1. ГЕГ-ын ЗББНДБ, харъяа гаалийн газар, хороодын 2025 | 1. ГЕГ-ын 2026 оны сургалтын төлөвлөгөөний саналыг ЗББНДБ-аас боловсруулуулан, нэгтгэж зардлын хамт СХОГ-т хянуулахаар хүргүүлсэн. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оновчтой тодорхойлон, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх | гүйцэтгэлээр | | оны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа авч нэгтгэж, ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулах<br>2.Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 1 ажил зохион байгуулах<br>3.Заах арга зүйг боловсронгуй болгох хүрээнд жишиг сургалтын хөтөлбөр боловсруулах. | 2. Гаалийн байгууллагын 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан сургалтуудад өөрийн заадаг "Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт", "Гаалийн үнэ, үнэлгээ" хичээлийн чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу лекц, PPT, слайд, үзүүлэн тараах материал, тест, кейс бэлдэн сургалтын үйл ажиллагаанд оролцсон. | | |
| 2 | Албан хаагчдыг чадавхжуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт 2 удаа /80 суралцагч/,<br>2. ГУБ нарын мэргэшүүлэх сургалт 2 удаа /50 ГУБ/,<br>3. Хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг чадавжуулах сургалт-1 удаа /30 ГУБ/<br>4. ДГБ-ын Дунд түвшний удирдлагын хөгжил сургалт -1 удаа /60 ГУБ/<br>5.Сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, зохион байгуулсан сургалтын тайланг нэгтгэн, үр дүн тооцсон байна. | 1. Сургалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд зохион байгуулагдсан "Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт"-д 2 удаа Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт хичээлээр нийт 14 цагийн хичээл орсон. Мөн шинээр ажилд орж буй албан хаагчдыг бэтгэх зорилгоор VR сургалтыг нийт 8 цагийн хичээлээр орсон.<br>2. Гаалийн улсын байцаагчдыг чадавхжуулах дунд шатны мэргэшүүлэх сургалтыг "Барааны ангилал, гаалийн тариф татвар, гаалийн үнэ, үнэлгээ"-ний чиглэлээр 2025 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтад Бүрдүүлэлтийн цахим төвийн 10 ГУБ, харьяа газар хорооны 15 ГУБ, нийт 25 ГУБ нар тус тус хамрагдсан болно. Уг сургалтад хөтөлбөрийн дагуу "Гаалийн тарифын зохицуулалт, татварын хөнгөлөлт чөлөөлөлт" сэдвээр хичээл заасан.<br>3. 2025.01.20, 2025.02.03, 2025.05.19 тус тус 3 удаа зохион байгуулагдсан хорио цээрийн хяналт хариуцсан ГУБ нарт гаалийн хэргийн мэдлэг олгох мэргэшүүлэх сургалтад "Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт", "Гаалийн үнэ, үнэлгээ" сэдвээр хичээл заасан. Мөн гаалийн албан хаагчдыг чадавхжуулах VR сургалтыг орсон. | 01.01-06.10 | 100 |
| 3 | Гааль судлалын хүрээнд хийгдсэн ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.МУИС-ийн багш нартай хамтран гаалийн байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлаар өгүүлэл, нийтлэл, судалгаа, бүтээл гарган, асуудлыг шийдэх боломжийн талаар санал боловсруулж, | 1. ГЕГ, МУИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд ГЕГ-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцсон. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удирдлагыг мэдээллээр хангана. | | | |
| 4 | Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br><br>1. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх олгох анхан шатны сургалт 1 удаа /60 хүн/зохион байгуулна.<br><br>2. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалт 2 удаа /150 хүн/зохион байгуулна | 1. 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс зохион байгуулагдсан ГБМ-ний анхан шатны эрх олгох сургалтанд “Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт” хичээлээр 8 цагийн сургалт орсон.<br>2. 2025 оны 5 дугаар сарын 5-наас МУИС-ийн Бизнесийн сургуультай хамтран зохион байгуулсан ГБМ-ний эрх олгох анхан шатны сургалтанд “Гаалийн үнэ, үнэлгээ”-ний чиглэлээр 10 цагийн хичээл орсон.<br>3. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтыг нийт 3 удаа зохион байгуулж 180 бүртгэгдсэн мэргэжилтнийг төгсгөсөн. Сургалт 2025.04.03, 2025.04.23, 2025.05.12 ГЕГ-ын Сургалтын төв дээр танхимын сургалтын хэлбэрээр зохион байгуулагдсан. Уг сургалтад “Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт” сэдвээр нийт 12 цагийн хичээл заасан.<br>4. 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр МУИС-ийн Бизнесийн сургулийн “Худалдаа” хөтөлбөрийн оюутнуудын үйлдвэрлэлийн дадлага хамгаалалтанд гаалийн байгууллагаас төлөөлөн оролцож, 12 оюутны тайланг хамгаалуулсан.<br>5. ИЗОУИС-ийн Санхүү, эдийн засгийн сургуулийн “Гаалийн менежмент, Гааль татвар эдийн засаг” -ийн хөтөлбөрөөр суралцдаг 90 оюутны улсын шалгалт, дипломын ажлыг хамгаалуулах төгсөлтийн шалгалтын комиссын гишүүнээр 2025 оны 04 сарын 19, 05 сарын 02 болон 04-ний өдрүүдэд багш-ГУБ Ч.Жаргалсайхны хамтаар ажилласан.<br>6. Багш-ГУБ О.Отгонгэрэл, Г.Тамир нарын хамтаар 2025 оны 05 дугаар сарын 22-нд Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн харьяа Бизнес консалтинг төвөөс зохион байгуулсан “JOB&CAREER Fair 2025” мэргэжил сурталчлах өдөрлөгт гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлого хөтөлбөрийг танилцуулж, оролцсон.<br>7. 2025 оны 05-р сарын 02-оос эхлэсэн цахимаар бараагаа өөрөө мэдүүлэх гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан сургалтанд “Гаалийн тарифын болон тарифын бус зохицуулалт”, “Гаалийн үнэ, үнэлгээ” сэдвээр 8 цагийн хичээл заасан. Уг сургалтад танхимаар болон цахимаар 90 гаруй ААН, байгууллагын төлөөлөл хамрагдсан. | 01.01-06.10 | 100 |
| 5 | Багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Гаалийн тариф, гаалийн татварын чиглэлээр мэргэших сургалтуудад хамрагдана. | 1. 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэсэн “Мөнгө угаах гэмт хэрэг” -ийн сэдвээр ХТМУТХ-ээс зохион байгуулсан 6 удаагийн сургалтад хамрагдсан.<br>2. Өөрийн заадаг хичээл болох гаалийн тариф, гаалийн татварын чиглэлээр гаалийн бүрдүүлэлтэд тулгамдаж буй мэдлэг, мэдээлэл олж авахаар ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд 2025 оны | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах | | | | 03 сарын 13-ны өдрөөс хоёр долоо хоногийн турш бичиг баримт хариуцсан гаалийн улсын байцаагчийг дагалдан, импортын барааны гаалийн үнэлгээ хийх болон үнэлгээний маргаан шийдвэрлэх үргүүдэд тус тус томилогдон ажилласан.<br>3. Үндэсний цахим 7 хоногийн хүрээнд зохион байгуулагдсан Digital trade сургалтад 2025 оны 03 дугаар сарын 27-29-ны хооронд хамрагдсан. | | |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | | | Эхний хагас жилд:<br><br>Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | 1. Дэлхийн Гаалийн Байгууллагаас 2024 оны 5 дугаар сарын 5-наас 10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Паласамудрам хотноо Ази, Номхон далайн бүсийн гаалийн байгууллагуудын сургалтын менежментийн уулзалт зохион байгуулагдсан. Тус сургалтын мөрөөр 2025 онд Монгол улсын гаалийн байгууллагын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Дэлхийн гаалийн байгууллагын Ази Номхон далайн бүсийн сургалтын төвд хүргүүлж шилдэг туршлагын нэгээр шалгарсан. Энэ хүрээнд 2025 оны 05 сарын 21 нд Хонконг улсад зохион байгуулагдсан Дэлхийн гаалийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Гаалийн байгууллагын дарга нарын 26 дугаар бага хурлаар албан ёсоор Монгол улсын илтгэлийг танилцуулсан. Мөн Дэлхийн гаалийн байгууллагын Азийн Номхон далайн бүсийн сургалтын менежментийн эмхэтгэлд Монгол улсын тайланг тэргүүн туршлагаар хэвлэгдсэн | | |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | | | Эхний хагас жилд:<br><br>1. Нэгжийн сургалтын эрсдэлийг тооцож ажиллах талаар арга хэмжээ авч ажиллах | 1. Багш-гаалийн улсын байцаагчид өвчтэй, чөлөөтэй болон бусад хүндэтгэж үзэх шалтгааны улмаас хичээл заах боломжгүй болох эрсдлийг тооцсоны үндсэн дээр нэг хичээлийн хөтөлбөрийг 2 ба түүнээс дээш багш зэрэг судлан, бие биенээ орлон, мөн хоршин ажиллах боломжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлыг ажлын байрны сургалт явуулахад анх турших эхэлсэн нь үр дүнтэй ажил болсон тул цаашид сургалтад энэхүү аргыг ашиглаж байна.<br>2. ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороод "Гааль судлалыг хөгжүүлэх" хөтөлбөр болон тухайн цаг хугацааны сургалтын төлөвлөгөөний биелэлтийн тайланг огт ирүүлдэггүй, хугацаа хоцроодрг зэрэг зөрчил, дутагдал гаргадаг тул энэхүү эрсдэлээс сэргийлж, төвөөс дараахь 2 арга хэмжээг авч ажилласан. Үүнд:<br>• ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодыг багш нарт хуваарилж өгсөн<br>• CERP програмаар ГЕГ-ын нэгжүүд, харъяа гаалийн газар, хороодод тайлан ирүүлэх талаар хугацаатай үүрэг, даалгавар өгсөн<br>3. ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсээс гаргасан "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан 2023"-аас зарим мэдээллийг өөрийн заадаг хичээлдээ ашиглаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Үүрэг даалгаварын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Өгөгдсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна.<br><br>2. Бусдад хүргүүлсэн үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | 1. Тайлант хугацаанд ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороод, бусад байгууллагаас цохогдон ирсэн албан бичгүүдэд хугацаанд нь хариу өгч, албан бичгийн дагуу зохих үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.<br>2. 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэсэн гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтын 40 суралцагчдын дадлага ажлын зөвлөх багшаар ажилласан.<br>3. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан нийт сургалтуудын суралцагчидаас сургалтын үнэлгээ, санал асуулга авч үр дүнг нэгтгэн, тайланг тухай бүрд удирдлагад танилцуулж байсан.<br>4. ГЕГ-ын болон Сургалтын төвийн даргын өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь биелүүлэн, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан.<br>5. 2025 оны 04-р сард ЗҮГГ-н албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу 27 ААН-ийн төлөөлөл 38 ГБМ-д “Гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт” сэдвээр цахимаар хичээл заасан. | 01.01-06.10 | 100 |
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br><br>1. Ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна.<br><br>2. Ажлын цаг ашиглалт өссөн/буурсан үр дүн, шалтгаан нөхцлийг тайлагнана. | 1. Тайлант хугацаанд нийт 124 хоног 992 цаг ажиллахаас өвдсөн, ажил тасалсан болон чөлөө авсан цаг байхгүй илүү ажилласан цаг 31, ажлын цаг ашиглалт 100 хувь бүрэн ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдлага арга зүйгээр хэрхэн хангаж ажилласан байдал, үр дүнг,<br><br>2. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, нэгжийн үйл ажиллагаанд ашиглагддаг програмын шинэчлэлт, хөгжүүлэлт, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан болон бүрэлдэхүүнд нь ажилласан байдал, аливаа зөвлөмжийн биелэлт зэрэг арга хэмжээг тус тус тайлагнана. | 1. 2025 оны 05 сарын 29-ний өдөр Гааль подкастын хоёрдугаар дугаарт “Гаалийн албанд залуу үеийн оролцоо” сэдвийн хүрээнд ярилцлага өгсөн.<br>2. 2025 оны 06 сарын 06-ны өдөр “Гаалийн албан хаагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ”-ний чиглэлээр Сэтгэл судлалын хүрээлэнгээс авсан судалгааны үр дүнгийн тайлагналтын хуралд оролцож, мэдээлэл авсан. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан. | 1. Хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж удирдлагаар баталгаажуулсан болно. | 01.01-06.10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ШУТИС-ийн "Багшлах эрх олгох сургалт" -д хамрагдаж үнэмлэх авсан байна | Үнэмлэхээр | - | Багшлах эрхийн үнэмлэх авсан байна | 1. ШУТИС-ийн Нээлттэй боловсролын хүрээлэнгийн багшлах эрхийн 30 хоногийн сургалтад хамрагдаж, багшлах эрхийн үнэмлэх авсан. | 01.01-06.10 | 100 |
| 2 | Байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мэргэшлийн мэдлэг чадвараа сайжруулна | Гүйцэтгэлээр | - | 2025 онд тавaас дээш сургалтанд хамрагдсан байна. | 1. Гаалийн байгууллагын "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх" сургагч багш бэлтгэх цахим болон танхим хосолсон 40 цагийн сургалтад 2025 оны 05 дугаар сарын 01-16-ны хооронд хамрагдаж, гэрчилгээ авсан. | 01.01-06.10 | 100 |
| 3 | Үндэсний тагнуулын академийн "Эрх зүй" бакалаврын хөтөлбөрийн 3,4-р улиралд суралцана. | Гүйцэтгэлээр | 2024 онд 1,2-р улиралд хамрагдсан. | 3-р улирлын сургалтад хамрагдсан байна | 1. Үндэсний тагнуулын академийн эрх зүйн бакалаврын эчнээ хөтөлбөрт хамрагдан, хавар /2025.04.21-2025.05.23 хооронд/ -ын улиралд амжилттай суралцаж төгссөн. | 01.01-06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

СУРГАЛТ ТӨВИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ……………… /Н.АНУЖИН/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НЯМДОРЖИЙН АНУЖИНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Сургалтын төв

### 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 7 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 57 | 10 | 67 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Сургалтын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлон, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх | 58.8 | 10 | 68.8 | |
| 2 | Албан хаагчдыг чадавхжуулах | 60 | 10 | 70 | |
| 3 | Гааль судлалын хүрээнд хийгдсэн ажил | 57 | 10 | 67 | |
| 4 | Бусад байгууллагатай хамтран ажиллах, захиалгат сургалт зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 5 | Багш нарын заах арга зүй, онол болон практикийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжоор хангах | 60 | 10 | 70 | |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58.8 | 10 | 68.8 | |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 58.8 | 10 | 68.8 | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 10 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 58.8 | 10 | 68.8 | |
| 12 | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажилагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 69 | |

### 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 13 | ШУТИС-ийн "Багшлах эрх олгох сургалт" -д хамрагдаж үнэмлэх авсан байна | 100 | 15 | |
| 14 | Байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мэргэшлийн мэдлэг чадвараа сайжруулна | 90 | 13,5 | |
| 15 | Үндэсний тагнуулын академийн "Эрх зүй" бакалаврын хөтөлбөрийн 3,4-р улиралд суралцана. | 100 | 15 | |
| | **Дундаж оноо:** | | 14.5 | |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | **Дундаж оноо:** | **6.6** | |

### 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 7 |
| 3 | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо: 7.6** | |

### 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 69 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.5 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.6 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7.6 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **97.7** |

***Үнэлгээ өгсөн:***
***Нэгжийн дарга:***
Сургалтын төвийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Ч.Мөнххишиг)
2025.06.10 ..........(огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ............................ (Н.Анужин)
2025.06.10 ..........(огноо)

***Үнэлгээг хянасан :***
***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч ............................ (Г.Энхтайван)
2025.06.25 .......................... (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч
............................ (Ө.Тэгшээ)
2025.06.25 ..................... (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***
***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ............................ (Р.Отгонжаргал)
2025.06.25 ..............................(огноо)